



СЭЛЭНГЭ АЙМАГ ЕРӨӨ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/12


Ерөө

Төрийн үйлчилгээний албан хаагчдын
албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан ажилтны албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Няравын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Үйлчлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Жижүүрийн албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Жолоочийн албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг албан хаагч бүрийн үйл ажиллагаанд мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн Б.Дашдэлэгт даалгасугай.



С.ЦЭВЭЛМАА

